



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 260

Улаанбаатар хот

**Хөрөнгө акталж данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 17 нэрийн, нийт 83,659,505.02 (наян гурван сая зургаан зуун тавин есөн мянга таван зуун таван төгрөг хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Б.Мөнхтамир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, ашиглаж болох материалыг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар ашиглах, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийн хамт 2023 оны 3 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005309  
14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 05 дугаар сарын .....-ны өдрийн  
.....160..... дугаар тогтоолын хавсралт

"МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж  
данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Контейнер	12/25/1998	1	ш	1,217,236.59
2	Контейнер	12/25/1998	1	ш	1,217,236.59
3	Контейнер	12/25/1998	1	ш	1,217,236.59
4	Контейнер	12/25/1998	1	ш	1,217,236.59
5	Токарийн суурь машин	1/8/1999	1	ш	4,000,000.00
6	Өрөм - Босоо 2H125	2/3/1999	1	ш	1,500,000.00
7	Угаалгын машин ARITSON	5/8/2013	1	ш	950,000.00
8	Хөргөгч	9/6/2013	1	ш	236,272.72
9	Принтер HP м1005	7/3/2014	1	ш	500,000.00
10	Угаалгын машин	9/1/1999	1	ш	44,220,000.00
11	Хими цэвэрлэгээний машин	12/30/2006	1	ш	13,002,154.00
12	Оёдлын машин	4/30/2008	1	ш	8,229,261.40
13	Хөлдөөгч вйлдвэрлэлийн	9/5/2005	1	ш	1,116,750.00
14	Агааржуулагч - AIR- коницон	6/30/2010	1	ш	1,485,605.73
15	Агааржуулагч - AIR- коницон	6/30/2010	1	ш	1,485,605.72
16	Агааржуулагч - AIR- коницо	6/30/2010	1	ш	1,227,272.73
17	Агааржуулагч	3/1/2011	1	ш	837,636.36
					83,659,505.02
	Нийт дүн				(наян гурван сая зургаан зуун тавин есөн мянга таван зуун таван төгрөг хоёр мөнгө)